

**АРВАН ХОЁР ЖИЛ
АРХЕОЛОГИЙН
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНД
ТУСГАГДСАН НЬ**

Х. Лхагвасүрэн

Төв Азийн өргөн уудам нутаг дэвсгэрт он удаан зуунаар оршиж, түүх, соёлын баялаг түүхээ үлдээсэн монголчуудын өвөг дээдэстэй холбогдох оюун сэтгэлгээний арвин их хэрэглэгдэхүүн эртний судлалын үр дүнд нилээд илэрч байна. Иймд эл удаа Монгол, Унгарын хамтарсан шинжилгээний анги¹ 1963 онд олж илрүүлсэн нэгэн сонирхолтой олборын талаар авч үзэх санаа өвөрлөв.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгой хэмээх газар гадаад байдлаараа дугуй хэлбэртэй, чулуун өрлөг бүхий (хүннүгийн жирийн иргэний холбогдолтой) булшийг малтжээ.

Уул (1-рх) булшны дараас чулууг авч малтлагыг үргэлжлүүлвээс 2 м гүнээс модон авсны үйрмэг, 2,25 см-ээс цайвар өнгийн ваарны хагархайнууд тус бүр илэрчээ. Тэрчлэн булшны нүхний хойт хэсгээс толгойг нь умар луу харуулсан, хоёр хүүхдийн яс гарчээ. Эндээс олдсон хэрэглэгдэхүүн дотроос зан үйлийн хувьд их л сонин нэг баримт бол, насанд хүрсэн эр, эм хоёрын тэргүүнийг чанх урагш чиглүүлэн оршуулсан явдал юм. Тэнд бүсгүй хүндээ ясан зүү, жижиг төмөр эдлэл, даруулга, эрэгтэйдээ чих цэвэрлэх зориулалттай нижгээд ясан эдлэл зэргийг дагалдуулжээ. Насан өөд болсон дээрх эмэгтэйн толгойны зүүн хэсгээс дугуйдуу үйсэнд (гэр болов уу) цуглаастай хүрэл цас толиний хагархай олджээ. Уул толин дээр нангиад (иеороглиф) бичээс байсныг Хан улсын үеийн дурсгал бололтой хэмээжээ.²

Энэхүү тольны хагархай нь 8 см урт, 6,5 см өргөн агаад төв хэсэгтээ 5 см урт дөрвөлжин хүрээтэй, түүний дотор ахин нэг дөрвөлжин буй нь 4,5 см хэмжээтэй байсан. Харин 2,7 см дугуй сэнжний гадуур нь хааш хаашаагаа 2,8 см хэмжээтэй өөр нэг дөрвөлжин хүрээг гаргасан байв. Хамгийн дотор талын дөрвөлжингийн гадна хэсэгт дүрс үсгийг сийлсэн бол гаднах хүрээг тойруулан амьтдыг товойлгож хийсэн байлаа. Уг толинд үлдсэн үсгийнхэн эмх цэгц утга санааны авцалдаа, байрлал зэрэгт тулгуурлан толины ерөнхий хэлбэр төрхийг гаргах оролдлого хийж, судлаачдын сонор, мэлмийд хүргэхийн хамт өөрийн ганц нэг санааг толилуулъя.

Хүрээлэн буй ахуй амьдралын шаардлага, сав ертөнцийн үзэгдэл юмс нь арван хоёр жилийг амьтдаар төлөөлүүлэх ойлголтын эхлэл байж. Ийм ч учраас элдэв төрлийн амьтдыг багтаасан цаг тооны цог цолбор дурсгалыг эртний хүмүүс бүтээсэн аж. Сарны орчим хувиралд шүтсэн арван хоёр жилийн тооллын эх үүсвэр эхийн эрхт овгийн байгууллын үед анх тавигдсан бөгөөд түүхийг бүтээлцэхэд өвөг монголчууд оролцсон гэлтэй байна.³

Тэд нэн түрүүн наран, саран, тэнгэр, байгаль дэлхийгээ бишрэн шүтэхдээ байгаль, цаг уур, улирлын байдлыг олон жилийн турш нарийн ажиглаж амьтны төрөх, үржих, ургамлын цэцэглэх үе, амьтны үр төл өсч торних үе, цаг улирлын дулаан, сэрүүн, хүйтэн болох үе гэх мэтчилэн жилийг дөрвөн улирал болгон, улирал бүрийг нарийн

тооцоолж жилийг 12 сард хуваан, сарны эргэлтэд тохируулан 12 амьтны мөчлөгдөх цаг тооллыг зохиожээ.⁴ Энэ нь тухайн үед гэнэт гарч ирээгүй түүхэн хөгжлийн явцад хөндөгдөн бий болсон үзэгдэл байж. Баянлиг, Чулуутын гол, Тэвш уул, Бичигт хад зэрэгт буй сүг зурагнуудад тэнгэр эрхис, одон ертөнц, ан амьтдыг дүрсэлсэн нь шууд биш гэлээ ч дам байдлаар бидний сэдэвтэй онолдох үндэс бий. Тэрчлэн хүрэл, төмрийн үеийн буган хөшөөнд нар, сарыг урласан баримт зөвхөн Төв Ази, Монгол оронд төдийгүй Өвөрбайгаль, Сибирь, Дундад Ази, Дунай Карпатын сав хүртэл тархсан байна. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Тээлд малтсан дундад эртний Монголчуудын булшнаас, долоон одыг хагас дугуйруулан сийлсэн ясан олбор олдсоноор мөшгөхөд он цагийн хувьд олон зууныг хамарч бидний өгүүлэн буй асуудал үргэлжилжээ.

Түрэгийн мэргэн сайд Кюльтегинд зориулж босгосон хөшөөний бичээсэнд «Дээр хөх тэнгэр, дор бол дэлхий, дунд нь хүний хүү төрснийг» онцолсноос харахад эрт үед доод, дунд, дээд ертөнц гэдэг ухагдахуун үүссэнийг илэрхийлж байна.

Дээрх баримтуудыг авч үзэхийн уг шаг болбоос, Монголчуудын өвөг дээдэс одод сансрын тухай зохих ойлголт, мэдлэгтэй байсныг гэрчлэхийн хамт арван хоёр жилийн мөчлөг олон зууны явцад хуримтлагдаж бий болсныг илэрхийлнэ.

Ийнхүү арван хоёр жилийн мөчлөгийн үүсэл гаралын тухайд бага сага өгүүлэхийн зэрэгцээ, булшинд хүрэл толь дагалдуулахын учир холбогдлыг товчхон өгүүлье.

Хүннү болон дундад эртний монголчуудын булшинд ихэвчлэн эмэгтэй нас барагсаддаа хүрэл толь тавьдаг зан үйл нилээд газар авсан нь ажиглагддаг. Гэхдээ ийн тавихдаа хагалж хийдэг горим ёс ихэд тархсаныг нурших юун. Тухайлбал Наваан багш, эрдэмтэн Ц. Доржсүрэн, Ц. Цэвээндорж нар эртний хүннүгийн булшнаас бүтэн хийгээд хагархай толинууд нижгээдийг илрүүлэн судалгааны хүрээнд оруулсан. Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд дурдан буй булшнаас төдийгүй саявтархан эрдэмтэн Д. Цэвээндорж Наймаа толгойд өөр нэгэн хүннүгийн оршуулгаас (9 см 7 мм Дм-тэй) хүрэл толь ирүүлсэн⁵ нь судалгааны хувьд чухал олбор болсон. Ийнхүү нас барагсаддаа толь дагалдуулдаг зан үйл хожимын дундад зууны үе хүртэл үргэлжилсэн болох нь Дарханы ойролцоох Бууралтын энгэр, Ховдын Мөстийн баруун ам зэрэг газарт малтсан Монгол булшны хэрэглэгдэхүүнээс тодорхой байна.

Хүндээ ийнхүү хагархай толь тавьдаг зан үйл нь угтаа тэр гэр бүлийн амьдрал ахуйд ан цав гарлаа, хагацаж хагарлаа хэмээсэн утга санааг илэрхийлсэн хэрэг гэж үзмой.

Хүннү нар амьтны мөчлөгийн 12 жилийн он тоолол хэрэглэж байсан гэх үндэс байгааг мэр сэр судлаач бүтээлдээ тусгасан⁶ бол, эрдэмтэн түүхч А. Дамдинсүрэн эртний хүннүчүүдийн дунд 12 жилийн мөчлөг үүссэн гэж үзжээ. Он цагийн тухайд арван хоёр жилийн амьтны мөчлөгийг дундад болон Төв Азийн нутаг дэвсгэрт балар эртний хүй нэгдлийн байгууллын харилцаа задарч, ангийн нийгмийн харилцаа үүсч байсан үеийн аймаг ястны дотор м.э.ө болон м.э эхэн зууны үед үүсчээ.⁷

Бидний дурдан буй эд өлөг нь арван хоёр жилийн тоолол, мээ эртний хүннүчүүдийн дотор хэрэглэгдэж байсанг бодитойгоор баталж

байна. Нөгөө талаар арван хоёр жилийн тоолол буй болсон нь тэр үеийн цаг тооллын мэдлэг ухаанд чухал алхам болж, нүүдэлчдийн оюун сэтгэлгээний соёл хэрхэн бүрэлдсэний нэг гэрч гэлтэй.

¹ Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд дэд эрдэмтэн Д. Наваан, археологич И. Эрдели нар оролцсон.

² Д. Наваан, Монгол унгарын хамтарсан экспедицийн тайлан. 1963 он.

³ А. Очир. Эртний монголчуудын цаг тооллын мэдлэгийг сарын нэрээр мөшгөх нь. Этнографийн судлал. Т. 1ХЗ. х 20.

⁴ А. Дамдинсүрэн. Арван хоёр жилийн гарал, үүслийн тухайд. Үнэн. 1990. 2. 25. № 48.

⁵ Д. Цэвээндорж. Хүннүгийн археологи. А. С. 1987. т. XIII с. 69,

⁶ Г. Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг. УБ., 1980. х 128. Т

⁷ И. М. Захаров Двенадцатлетний животный цикл у народов центральной Азии-Новые материалы по древней и средневековой истории Казакстана. Алма-Ата, 1960. с 61, 64.